



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 8/51

Бор-Өндөр сум

**Н.Уранбайгалийг бага ангийн багшаар
эгүүлэн томилох тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, 60 дугаар зүйлийн 60.1.3, 61 дүгээр зүйлийн 61.1.4, 101 дүгээр зүйлийн 101.1, 139 дүгээр зүйлийн 139.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 128 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нямдаваагийн Уранбайгаль нь ажилдаа эргэн орох хүсэлт гаргасан тул 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн бага ангийн багшийн албан тушаалд эгүүлэн томилсугай.

2.Н.Уранбайгалийн албан тушаалын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэл 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг бага ангийн багш (Н.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Ч.АМАРЖАРГАЛ